

SNSagent API — Заавар

platform.snsagent.shop · Facebook, Instagram, YouTube мессежийг өөрийн н8н руу · хувилбар 2026-09-07

Бүх хүсэлтэд **Authorization: Bearer <түлхүүр>** толгой хэрэгтэй. Хязгаар: түлхүүр тутамд 120 дуудлага/минут.

1. Мессеж хүлээж авах (бид → танай н8н)

н8н дээр **Webhook** node үүсгээд, түүний Production URL-ыг дээрх талбарт тавина. Хэн нэгэн танай хуудсанд бичихэд бид энэ хаяг руу POST хийнэ:

```
{
  "event": "message.received",
  "pageId": "pg_a1b2c3...",
  "platform": "facebook",
  "conversationId": "...",
  "from": { "id": "...", "name": "Болд" },
  "text": "Энэ хэдэн төгрөг вэ?",
  "attachments": [],
  "at": "2026-08-06T12:00:00.000Z"
}
```

Бид ЗӨВХӨН ирсэн мессежийг дамжуулна — таны илгээсэн хариу буцаж ирэхгүй тул хязгааргүй давталт үүсэхгүй.

2. Хариу илгээх (та → хэрэглэгч)

н8н дээр **HTTP Request** node:

```
POST https://platform.snsagent.shop/v1/messages
Authorization: Bearer sk_live_...
Content-Type: application/json

{
  "pageId": "pg_a1b2c3...",
  "conversationId": "...",
  "text": "Сайн байна уу! 179,000₮."
}
```

3. Гүйлгэдэг цомог (carousel)

Меню, багц, ажлын жишээ үзүүлэхэд хамгийн хүчтэй хэлбэр. 10 хүртэл карт, карт бүрд 3 хүртэл товч.

```
POST https://platform.snsagent.shop/v1/carousel

{
  "pageId": "pg_...",
  "conversationId": "...",
  "cards": [
    { "title": "Улаан мөөг дэр", "subtitle": "179,000₮",
      "imageUrl": "https://.../der.jpg",
      "buttons": [ { "type": "postback", "title": "Захиалах",
        "payload": "BUY_024" } ] },
    { "title": "Сансрын дэр", "subtitle": "199,000₮", "imageUrl":
      "https://..." }
  ]
}
```

⚠ Зураг 1200×628 (1.91:1) байх ёстой — Facebook бүх картыг тэр харьцаагаар таслана. Дөрвөлжин зураг дээр/доор нь тасарна. `imageUrl` нь **https** ба гаднаас нээгддэг байх ёстой.

4. Товч ба хурдан хариулт

Энгийн мессежтэй хамт илгээнэ. **buttons** болон **quickReplies**-г ЗЭРЭГ илгээх боломжгүй.

```
POST https://platform.snsagent.shop/v1/messages

{
  "pageId": "pg_...", "conversationId": "...",
  "text": "Аль нь тохирох вэ?",
  "buttons": [
    { "type": "postback", "title": "Захиалах", "payload": "ORDER" },
    { "type": "url", "title": "Дэлгэрэнгүй", "url": "https://..." }
  ]
}
```

Товч дарахад тэр даралт танай `webhook` руу ирнэ — `payload`-оор нь ялгаж боловсруулна.

ДҮРЭМ	ХЯЗГААР
Товчны төрөл	url · postback · phone (зөвхөн Facebook)
Цомгийн картын товч	зөвхөн url, postback
Товчны гарчиг	20 тэмдэгт
Нэг мессеж/картад	3 товч
Хурдан хариулт	13 ширхэг, payload ЗААВАЛ
Картын гарчиг	80 тэмдэгт
url товч	заавал https

5. Зураг, видео илгээх

```
POST https://platform.snsagent.shop/v1/image

{
  "pageId": "pg_...", "conversationId": "...",
  "url": "https://.../зурар.jpg",
  "type": "image",
  "caption": "Улаан мөөг дэр – 179,000₮"
}
```

type: image · video · audio · file. Хаяг нь https ба ил тод хүрэхүйц байх ёстой.

6. Яриануудаа харах

```
GET https://platform.snsagent.shop/v1/conversations?pageId=pg_...&limit=20

{ "conversations": [ { "id":"...", "from":{"id":"...", "name":"Болд"},
  "lastMessage":"...", "unread":2, "at":"..." } ] }
```

7. Ярианы түүх

Хэрэглэгч юу гэж бичсэнийг сануулахад, эсвэл AI-д контекст өгөхөд хэрэгтэй.

```
GET
https://platform.snsagent.shop/v1/conversations/{conversationId}/messages?
pageId=pg_...&limit=30

{ "messages": [ { "direction":"incoming", "text":"...", "at":"..." } ] }
```

8. «Бичиж байна» төлөв

Хариу бэлдэж байхад хэрэглэгчид харагдана — хүлээх мэдрэмжийг сайжруулна.

```
POST https://platform.snsagent.shop/v1/typing

{ "pageId": "pg_...", "conversationId": "..." }
```

9. Хуудсуудаа харах

```
GET https://platform.snsagent.shop/v1/pages

{ "pages": [ { "id": "pg_a1b2c3...", "platform": "facebook", "name": "Миний
дэлгүүр" } ] }
```

10. Бүртгэлийн мэдээлэл

```
GET https://platform.snsagent.shop/v1/me
```

11. Бүрэн хандалт — /v1/z/*

Дээрх боолтуудаас илүү зүйл хэрэгтэй бол платформын **бүх боломжийг** шууд ашиглана: постын хуваарь, коммент хариулт, analytics, Instagram story, Messenger цэс, ice-breaker гэх мэт 300 гаруй үйлдэл. Хүссэн замаа /v1/z/-ийн ард залгана.

```
GET https://platform.snsagent.shop/v1/z/inbox/conversations?pageId=pg_...
POST https://platform.snsagent.shop/v1/z/posts
GET https://platform.snsagent.shop/v1/z/accounts/pg_.../instagram/stories
PUT https://platform.snsagent.shop/v1/z/accounts/pg_.../messenger-menu
```

- **pageId**-г ердийнхөөрөө бичнэ — систем дотооддоо хөрвүүлнэ.

- Өөр хүний хуудас руу хандвал **404** (байгаа эсэхийг ч мэдэгдэхгүй).
- Профайл, webhook, холболт, төлбөр, багийн зам **хаалттай** — эдгээр нь харилцагчдын хоорондын хил.
- Хариу нь тэр чигтээ буцна, зөвхөн дотоод нэршил цэвэрлэгдэнэ.

Алдааны код

КОД	УТГА
401	Түлхүүр буруу, эсвэл эрхийн хугацаа дууссан
404	Тэр <code>pagelid</code> танайх биш, эсвэл байхгүй
429	Хэт олон дуудлага — <code>Retry-After</code> секунд хүлээнэ
5xx	Түр зуурын алдаа — дахин оролдоно уу

Анхаарах зүйлс

- Webhook 10 секундэд хариу өгөх ёстой. Урт ажил бол эхлээд 200 буцаагаад ард нь гүйцэтгэ.
- Дараалсан 20 удаа амжилтгүй болвол дамжуулалт зогсоно — хаягаа зассаны дараа сэргэнэ.
- **pagelid** тогтмол. Хадгалж аваад ашиглаж болно.
- Түлхүүрээ нийтэд БҮҮ ил гарга. Алдвал энэ хуудаснаас шинээр үүсгэ.